

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ (2013 оны эхний хагас жилд)

I. ТӨСӨВ: 2013 оны 1-р сарын 1-нээс “Төсвийн тухай хууль” шинээр хэрэгжиж эхэлснээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, соёлын байгууллагууд, хүүхэд гэр бүлийн хэлтэс, газрын алба, халамж асрамжийн үйлчилгээ зэрэг зардлууд орон нутгийн төсвөөс санхүүжих болсонтой холбоотойгоор төсвийн зардал ихээр нэмэгдэж байна.

Мөн орлогын хувьд орон нутагт төвлөрдөг байсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр нь улсын төсөвт төвлөрдөг болсон.

Дээр нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулдаг болсон.

Аймгийн төсвийн орлогод 36.2 тэрбум төгрөг орж, орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 30.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Эхний 3 дугаар улирлын байдлаар 4.8 тэрбум төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үед хийгдсэн төсвийн хөрөнгө оруулалттай харьцуулахад 10.4 дахин их байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хас, Төрийн банк, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 70.5 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 23.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 26.2 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 0.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 85.6 хувь болох 850.9 мянган эх мал төллөж, гарсан төлийн 98.8 хувь болох 850.3 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 91.7 мянган толгойгоор дээгүүр байна.

Оны эхний малын 0.9 хувь болох 20.9 мянган том мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.1 хувьтай байна.

Газар тариалан: Үр тариа 430 тн, төмс 668.2 тн, хүнсний ногоо 254 тн, техникийн ургамал 20 тн-ыг хураагаад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс төмс 36.8 тн, хүнсний ногоо 54.6 тн-оор тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Байгалийн хадлан 10.3 мянган тн, гар тэжээл 523.5 тн тус тус бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс хадлан 141.5 тн, гар тэжээл 40.5 тн-оор доогуур гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 20.8 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2 тэрбум төгрөгөөр буюу 0.9 хувиар доогуур байна.

Оны үнээр 73.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 19.2 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс нарийн боов, бялуу, тараг, дулаан, тоосго, блок, замын хавтан, яндан, пийшин, түлээний авдар, угаалтуур, түмпүн, тогооны таг, хогийн утгуур, савар, агааржуулагч, галын хайч, хаалт, жигнүүр, монгол цамц, сандал, эсгий, хаалганы үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО: Барилга: Барилга угсралт, их засварын ажил 16970.8 сая төгрөг болж, 2789.3 сая төгрөг буюу 16.4 хувь нь өөрийн аймгийн, 14181.5 сая төгрөг буюу 83.6 хувь нь гадны барилгын байгууллагуудад ноогдож байна. Барилга угсралт, их засварын ажил өнгөрсөн оны мөн үеэс 5653.6 сая төгрөг буюу 49.9 хувиар өсчээ.

Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 43.2 сая.тн.км-ийн ачаа эргэлт, 21.6 сая.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж, 6.4 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Холбоо: Холбооны ашиглалтын орлого 331.1 сая төгрөгт хүрсний дотор 129.8 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 684 байна.

VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 9-р сард өмнөх 2012 оны жилийн эцсийнхээс 7.2 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 9.2 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 14.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 6.4 хувь, тээврийн бүлгийн үнэ 2.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 9.5 хувь, боловсролын үйлчилгээ 30 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 11.8 хувь, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 15.6 хувиар тус тус өссөн байна.

VII. СОЁЛ, БОЛОВСРОЛ: **Соёл:** ХЖТеатр 57 мянган үзэгчдэд 38 удаа тоглолт хийж, 77.9 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Музей: 2.0 мянган үзмэрээр 1.7 мянган хүнд үйлчилж, 1292.9 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийтийн номын сан: 22.5 мянган уншигчдад 44.7 мянган номоор үйлчилж ажиллажээ.

Боловсрол: 2013-2014 оны хичээлийн жилд нийт 17 ЕБС-д 5105 үндсэн багш багшилж, 355 бүлэгт 9.8 мянган сурагчид суралцаж байна. Үүнээс 1-р ангид 1015 сурагч элсч, 11-р ангид 456 сурагч суралцаж байна. Аймгийн хэмжээнд нэг багшид дундажаар 19 хүүхэд ноогдож байна. 950 сурагч дотуур байранд сууж байна.

VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 5.8 тэрбум төгрөг болж төлөвлөгөөгөө 6.9 хувиар давж биелэв. Сайн дурын даатгуулагчид 186.2 сая төгрөгний шимтгэл оруулсан байна. 6388 өндөр настанд 10.7 тэрбум төгрөгийн тэтгэвэрийг бүрэн олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 2.0 тэрбум төгрөгийг 5.0 мянган иргэнд, улсын төсвөөс 1.3 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 6.7 мянган иргэнд олгосоны дотор хүний хөгжил сангаас 79.6 сая төгрөгийг 85 иргэнд тус тус олгосон байна.

IX. ЭРҮҮЛ МЭНД: 911 эх амаржиж, 917 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна.

Халдварт өвчнөөр 794 хүн өвчилсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 309-өөр олон байгаа бөгөөд гахай хавдар, тэмбүү, салхинцэцэг, сүрьеэ, заг зэрэг өвчлөлүүд өссөн байна.

X. АЖИЛГҮЙЧҮҮД: Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 866 болж, өнгөрсөн оны мөн үеэс 11-н хүнээр буурсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 61.28 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 21 хувь нь дээд, 6.8 хувь нь тусгай дунд, 40.5 хувь нь бүрэн дунд, 5.6 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

3 дугаар улиралд 1980 хүн шинээр бүртгүүлж, 1038 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 578 хүн ажиллаж байна.

XI. ГЭМТ ХЭРЭГ: 224 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 48-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 25 хүн нас барж, 92 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 431.3 сая төгрөгийн хохирол учирсны 83.7 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 233 хүн холбогдон сэжиглэгдсэний 34.3 хувь нь согтуугаар, 24.5 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1923 хүн эрүүлжигдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 604 хүнээр буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 404 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

XII. МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ: Малын индексжүүлсэн даатгалд 629 өрх 71.2 сая төгрөгөөр малаа даатгуулсан байна.

XIII. ДААТГАЛ: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 489.1 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 95 хувиар өссөн байна. 349 хүнд 88.7 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосоны дотор авто тээврийн хэрэгсэлд 3.6 сая, гэнэтийн осолд 2.5 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 63.9 сая, жолоочийн хариуцлагад 17.1 сая, иргэний эд хөрөнгөд 0.6 сая, хүүхдийн гэнэтийн осолд, гэр хашаа байшинд 0.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалд 0.1 сая төгрөгийг тус тус олгожээ.

XIV. ТӨСӨЛ: ЖДҮДСАН: Аймгийн хэмжээгээр жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөлд хамрагдахаар 1.8 тэрбум төгрөгийн 51 төслийг иргэд ирүүлснээс 480.0 сая төгрөгний 17 төсөл шалгаран батлагдаж санхүүжилтээ авсан нь өнгөрсөн онтой харьцуулахад төслийн тоо 60 хувиар, санхүүжилт нь 50 хувиар тус тус буурчээ.

XV. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 7212 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 6787 иргэнд 626.21 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байгаагийн дотор 2013 оны 3-р улирлын байдлаар 230 иргэн өргөдөл гаргаж, 14.05 га газрыг өмчлүүлэх шийдвэрээ гаргуулсан байна.



АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ

